

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Ц. Бавуудай

**«ДӨРВИЙН БҮЛГИЙГ» ШҮҮМЖИЛЖ БАЙГАА
КАМПАНИ БОЛ МАОИЗМЫН ЭЭЛЖИТ ХЯМРАЛ МӨН**

БНХАУ байгуулагдсанаас хойш Хятад орныг бүхэлд нь хамарсан улс төр, эдийн засаг, үзэл суртлын кампани олон удаа явагджээ. Тэдгээр кампанийг Мао Цзэ-дуны заавар шийдвэрээр, түүний шууд удирдлагын дор явуулж байсан нь мэдээж болсон юм. Харин энэ удаагийн «дөрвийн бүлгийг шүүмжилж буй кампани Хуа Го-фэний шууд заавраар хийгдэж байгаа нь нэгэнт тодорхой болжээ. Маог нас барсны дараахан Хятадын удирдах бүлгийн дотор аанай л засгийн эрхийг булаалдан тэмцэлдэж, Хоёр тал болсон тэрхүү тэмцлийг Маогийн бэлэвсэн гэргий Цзян Цин, төрийн зөвлөлийн ерөнхий сайд Хуа Го-фэн нар тус тус толгойлон богинохон хугацаанд ширүүн өрсөлдөн тэмцэлдсэн билээ. Эцэст нь Хуагийн тал ялж, Цзян Циний тал ялагдаж улс төрийн тайзнаас зайлуулагджээ.

1976 оны 10-р сарын 22-ны өдөр Хятад орныг нөмөрсөн улс төрийн шүүрүүн тэмцэл эхэлснийг хятадын хэвлэлд албан ёсоор зарлав. Энэ өдрийн «Жэньминь жибао» сонины 1-р нүүрт «Хуа Го-фэнийг Намын Төв Хорооны дарга, НТХ-ны цэргийн зөвлөлийн дарга болсон хийгээд «дөрвийн бүлгийн» нам төрийн мэдлийг булаан авах гэсэн хуйвалдааныг бут цохисон ялалтанд баяр хүргэе» гэсэн гарчиг бүхий өгүүлэл нийтлэгдсэнээр Маогийн бүлгийн дотор ноцтой хямрал гарсныг хятадын удирдагчид, хэрэг дээрээ хүлээн Зөвшөөрч ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга Мао Цзэдуны бэлэвсэн гэргий Цзян Цин, ХКН-ын Төв Хорооны орлогч дарга Ван Хун-вэнь, Намын Төв Хорооны улс төрийн товчооны байнгын хорооны гишүүн Чжан Чун-чяо, Намын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн Яо Вэнь-юань нарыг «дөрвийн бүлэг» гэж албан ёсоор зарлахын зэрэгцээ тэдний ажил явууллагыг илчлэн шүүмжлэхийг уриалжээ.

«Дөрвийн бүлгийг» шүүмжлэх кампанийг зохион явуулж байгаа арга барил ба түүний явцыг судлан үзэхэд аанай л Маогийн заавраар хийлгэж байсан урьд өмнийн кампаниудын нэгэн адил болох нь тодорхой байна. Гагцхүү хөдөлгөөний үнэн дүр, шинж чанараар нь авч үзвэл Маогийн үзэл санааг шүүмжлэн дайрч байгаа хэдий боловч Мао Цзэдуны үйлдсэн бүх нугалаа завхралыг «Дөрвийн бүлэгт» тохож, Маог гэм буруугүй болгон сугалж үлдээхийг хичээж байна.

Мао Цзэ-дун бол өөрийн хувийн эрх ашиг, нэр хүндийн төлөө улс үндсээ ч бодохгүй, эхнэр хүүхэд, найз нөхөр, хамтран зүтгэгчдээ ч золиосонд гаргахаас сийхгүй цэвдэг сэтгэлтэн хүн байсан болохоор түүний үхсэний дараа алдар нэрийг нь өчүүхэн ч гэсэн хадгалж явж чадах хүн авгай нь биш, Хуа Го-фэн байж болох юм гэж тэр амьд ахуйдаа бодож төрийн эрхийг Хуа-д шилжүүлсэн байж болох юм. Гэвч түүний төр удирдах чадвар хомс, туршлага дутуу зэрэг байдалд Мао санаа зовсоор нас эцэслэсэн бололтой. Дээрх дүгнэлт үнэн болохыг Хятадын Коммунист Намын XI их хуралд намын дүрэмд өөрчлөлт оруулах тухай Е Цзян-иний тавьсан илтгэлийн агуулгаас тодорхой болж байна. Тэрхүү

илтгэлд: «нөхөр Хуа Го-фэний тавьсан улс төрийн тайлан илтгэл нь Мао даргын гэрээслэлийг биелүүлэх, түүний заасан пролетарийн хувьсгалт чиг шугамаар цаашид ялгуусан давшилт хийсэн . . . Нөхөр Хуа Го-фэн бол Мао дарга өөрөө шилж тогтоосон залгамжлагч мөн» гэжээ.¹ Мөн цааш нь өгүүлэхдээ: «1976 оны 4-р сард Мао даргын саналаар нөхөр Хуа Го-фэнийг ХКН-ын Төв Хорооны 1-р орлогч дарга, төрийн зөвлөлийн ерөнхий сайдын тушаалд томилох тухай Намын Төв Хорооны Улс төрийн товчоо шийдвэрлэн, нам төрийг удирдах хамгийн чухал хариуцлагатай үүргийг түүнд даалгасан юм. Манай намын түүхэнд Төв Хорооны нэгдүгээр орлогч даргын албан тушаалыг бий болгож байсан удаа хэзээ ч байгаагүй. Энэ бол нам төрийн дээд эрхийг булаан авахыг санаархсан «дөрвийн бүлгийн» хатгалгын эсрэг чиглэсэн, дарга Маогийн маш чухал холч мэргэн шийдвэр мөн байлаа»² гэх мэтээр дурдсан байна. Хэдийгээр их хурлын материалд орсон эдгээр «гэрээслэл», «заалт»-ууд нь нэгд нэггүй бүрэн ул үндэстэй зүйл биш ч гэсэн Мао Цзэ-дун амьд ахуйдаа Аюу-дарай илүү найдвар тавьж, нам төрийнхөө эрхийг шилжүүлсэн баймаар гэж дүгнэх үндэс гарч байна.

«Дөрвийн бүлгийг» шүүмжлэх эл кампани бол БНХАУ байгуулагдсанаас хойш Хятадад явагдаж буй II дэх удаагийн улс төрийн кампани гэж Хятадын Коммунист намын XI их хурал албан ёсоор зарласан юм. Энэ нь Хятадын удирдах хэсгийн дотор үргэлжилсээр ирсэн засгийн эрхийн төлөө хурц тэмцлийн ээлжит нэг хувилбар юм. Үүгээр хэдэн зүтгэлтнийг хань хамсаатны нь хамт улс төрийн тавцангаас зайлуулсанаас биш, Бээжингийн бодлогод үндсэн өөрчлөлт гаргасангүй хэмээн манай намын төв хэвлэлд дүгнэж бичсэн байна.³

Одоо уг кампани нь «дөрвийн бүлгийн» үйл ажиллагааны хор уршгийг арилгах гэдэг шинэ шатандаа орж бүх Хятадыг хамарсаар байна. «Дөрвийн бүлгийг» илчлэн шүүмжлэх кампанийн явцыг ажиглахад түүнийг хэд хэдэн үе шатанд хувааж болохоор байна. Тухайлбал, далдуур шүүмжилсэн үе, албан ёсоор зарлаж шүүмжлэх болсон үе, муж, район болон албан байгууллагын хэмжээнд шүүмжилж эхэлсэн үе, хүн нэг бүрт ял оноож шүүмжлэх болсон үе, дөрвийн бүлгийн хор уршгийг арилгах кампанит ажил гэх мэтчилэнгээр хуваан үзэж болох юм. Үүнд:

1. 1976 оны 9-р сарын 9-нд Мао Цзэ-дуны нас барснаас хойш сар ч болоогүй байхад Маогийн бэлбэсэн эхнэр болон ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны бусад гурван гишүүн БНХАУ-ын улс төрийн тайзнаас зайлуулагджээ.

Хятадын төвийн сонинд тэр цагаас хойш хэн нэгэн хүнийг занаж зүхсэн битүү санаа агуулсан далд утга бүхий гарчигтай өгүүлэл олныг нийтэлж байв. Жишээ нь: «Марксизм, Мао даргын үзэл санаанаас урвагчидтай эцэст нь хүртэл тэмцэж, Мао даргын гурван үндсэн заалтыг зөрчсөн үг яриа, үйл ажилтай эрс шийдэмгий тэмцэе» гэх мэт үгтэй материалыг сонины дугаар бүр, нүүр бүхэнд бичдэг болсон байлаа. Мөн энэ үеэс эхлэн «хагарал гаргагчдын» тухай бичиж тэдэнтэй шийдвэртэй тэмцэхийг уриалахын зэрэгцээ «тэдгээр хүмүүс бол ажилчин ангийн эвлэршгүй дайсан ..., нам төрийн эрх мэдлийг булаах гэсэн хүмүүс бол намын доторхи жинхэнэ хөрөнгөтөн ангийн төлөөлөгч мөн»⁴ гэсэн агуулга

1. ХКН-ын XI их хуралд намын дүрэмд өөрчлөлт оруулах тухай Е Цзян-иний тавьсан илтгэл, 1977.8.13.

2. Мөн тэнд.

3. «Намын амьдрал» сэтгүүл, 1977, № 11. 77-р тал.

4. «Жэньминь жибао» 1976.10.14.

бүхий өгүүлэл нийтлэх болсон нь Хятадын дотоод улс төрийн байдал дахин хурцдасныг харуулсан билээ. Ийнхүү Ван, Чжан, Цзян, Яо нар бол чухам тийм этгээдүүд юм гэсэн ойлголтыг олон нийтэд аажмаар бүрэн өгч амжаад тэднийг илэрхийгээр шүүмжлэн хэлэлцэхэд зохих бэлтгэлийг хийсэн үе байв.

2. 1916 оны эцсээр Хятад орон даяар «дөрвийн бүлгийн» үйл ажиллагааг уудлан илчлэх, шүүн хэлэлцэх кампанит ажил хурц шатандаа орж Хятадын сонинууд «дөрвийн бүлгийг» шүүмжилсэн материалаар дүүрэх болов. Гэвч тэдгээр материалыг нарийвчлан үзэхэд гарчиг нь өөр өөр боловч утга агуулга нь нийтлэг бөгөөд ихэвчлэн «Жэньминь жибао» сонины тэргүүн өгүүлэлд нийтлэгдсэн зүйл буюу Хуа Го-фэний хэлсэн үгийн цар хүрээнээс хэтрүүлэхгүйг хичээсэн байдал ажиглагдав. Учир нь, Хятад улс байгуулагдсанаас хойш явуулж ирсэн удаа дараагийн улс төрийн кампанит ажилд өртөгдсөн хятадын ард түмэн «дөрвийн бүлгийн» эсрэг, тэр тусмаа Маогийн эхнэр оролцсон бүлгийн тухай ярина гэдэг бол ухаан санаанд нь багтмааргүй хэрэг байсан болохоор уг асуудалд «хашир» хандах нь зүйн хэрэг байв. Харин тэр үеийн шүүмжлэлд гарсан нэгэн онцлог зүйл гэвэл дөрвийнхөн Маогийн эсрэг давшилж байсан ба тэд Чжоу Эн-лайг дайран довтолж, түүнийг хорлосон⁵ гэж ч бичиж эхэлсэн юм.

Гэвч «Дөрвийн бүлэг» нь Маогийн эсрэг ажиллаж байсан гэдэг бол ор үндэсгүй зүйл юм. Мао тэд нараар өөрийн зорьсон бүхнийгээ үйлдүүлж байсан ба «дөрвийн бүлэг» ч Маогийн зааврыг хэрэгжүүлж байсан нь илэрхий. Нэг үгээр хэлэхэд, Маогийн бүлэг нам төрийн эрх булаан авахын тулд «соёлын хувьсгал» гэгчийг явуулж түүний үр дүнд нам төрийн дээд эрхийг гартаа оруулж авсан бөгөөд Мао, «дөрвийн бүлэг» хоёр харилцан шүтэлцэж байсан гэдгийг «соёлын хувьсгалын» бүх явц нотолж байна. Харин Чжоу Эн-лайг дайрч, хорлох гэж байсан гэдэг нь үнэний хувьтай байж болох, яагаад гэвэл Чжоу Эн-лай бол «дөрвийн бүлгийн» хийж буй ажил бүхнийг нэг их таашааж байгаагүй болов уу. Харин ХКН-ын Х их хурлаас хойш Чжоу, «дөрвийн бүлгийн» хоорондох зөрчил тэмцэл илэрхийгээр хурцдаж ирсэн болох нь илт мэдэгдэх болсон юм.

Маог амьд ахуй цагт 1973 оны 8-р сард хуралдсан ХКН-ын Х их хуралд Чжоу Эн-лайгийн тавьсан тайлан илтгэлд: Линь Бяо болон бүлэг этгээдийн» гараас нь үгийн түүвэр, амнаас нь мандтугай салдаггүй, тэд нүүрэн дээр нь сайхан үг хэлж, ар хударгаар нь хорт явуулга хийхийг оролдож байна. . . . Линь Бяогийн хэрэг явдал шиг хэрэг явдал цаашид арав, хорь, гучин удаа гарах болно»⁶ гэж дурдсан нь чухамдаа Чжоу Эн-лай тэр үед Ван, Чжан, Цзян, Яо нарыг тийм этгээдүүд гэж хэлж байсан бололтой. Одоо «дөрвийн бүлгийн» бүхий л үйл ажиллагааг Линь Биотой холбон шүүмжилж байгаагаас үзэхэд Чжоу Эн-лайн дээр хэлсэн үг нь санамсаргүй хэрэг биш гэдгийг нотолж байна. Нөгөө талаар «дөрвийн бүлэг» чухам энэ үеэс бүрэлдэж эхлэсэн гэдгийг бас харуулж байна. Одоо үед «дөрвийн бүлэгтэй» Линь Бяогийн хэргийг холбон тавьж, нэг амьсгаатай байсан мэтээр шүүмжилж байгаа нь тэдний хэргийг бүх талаар хүндрүүлж Мао-г цагаатгах гэсэн арга заль мөн. Чжоу Эн-лай «дөрвийн бүлгийн» хоорондох бас нэг хурц зөрчил гэвэл Чжоу Эн-лайн санаачлагаар Дэн Сяо-пинийг дахин гарган ирж, ХКН-ын Төв Хорооны орлогч дарга, бараг ерөнхий сайдын 1-р орлог-

5. Жэньминь жибао. 1976—11—16.

6 Чжоу Эн-лай, ХКН-ын Х их хуралд тавьсан тайлан илтгэл. «Жэньминь жибао» 1973—9—1. 2-р нүүр.

чийн хэмжээнд дэвшүүлэн тавьсан явдал юм. Энэ бүхэн нь «дөрвийн бүлгийн эрх мэдэл булаацалдах замд давхар саад болсон учир Чжоу Энх-лайг устгах нь «дөрвийн бүлэгт» Дэн Сяо-пинийг устгахаас илүү чухал байв. Чжоу Энх-лайгийн бие муу байсан явдал тэдэнд зорилгоо хангахад нь чухал нөхцөл болсон байна.

«Дөрвийн бүлгээс» Чжоу Энх-лайн эсрэг хийж байсан ажил явдлын тухай хятадын өөрийнх нь хэвлэлийн мэдээнээс авч үзвэл «дөрвийн бүлэг» нь Чжоу Энх-лайд хийх эмчилгээг саатуулах, түүнийг эмчилж байсан эмч нарыг сольж өөрчлөх зэрэг аргаар эмчилгээний горимыг алдагдуулж, өвчнийг даамжруулах замаар хорлосон байна»⁷. Түүнийг няцаасан баримт одоогоор үгүй тул уг хэрэг үнэн ч байж болох юм. Юу боловч Чжоу Энх-лайг оршуулсны дараахан Дэн Сяо-пинийг бүх албан тушаалаас нь авч хаясан явдал Чжоу ба «дөрвийн бүлгийн» хооронд ноцтой зөрчил байсан гэдгийн бас нэг том нотолгоо мөн.

Хэрэв Чжоу Энхлай Маог залгамжлан үлдсэн бол мөн л маоизмыг үргэлжлүүлэх байхсан. Гэхдээ арай өөр маягаар явуулах байсан болов уу. Юу гэвэл Чжоу Энх-лайн хувийн зан байдлыг гадаадын судлаачид: «Чжоу Энх-лай төрийн эрхийн төлөө Маотай шууд халз тэмцэлдэх явдал гаргадаггүй, тэр өөрийгөө хэт товойлгон гаргахаас маш болгоомжилдог байсан. Ялангуяа өөрийн талын тодорхой бүлэг зохиохоос зайлсхийдэг. Харин бусад бүлгүүдийн хоорондох тэмцэл зөрөлдөөнийг эвлэрүүлэх үүрэг гүйцэтгэдэг байв. Тийм ч учраас Хятад дахь ямар нэгэн бүлэглэл бутцохиогдох үед тэр өртөгдөн бай болж хэзээ ч байгаагүй бөгөөд түүнээс цэвэрхэн сугарч үлддэг байжээ. Тиймээс ч Чжоу нь Маод хэрэгтэй хүн байсны дээр Мао нь Чжоуг ашиглан өөрийн эсрэг хандсан олон бүлгүүдийн тэмцлийг намжаан эвлэрүүлж хэвийн байдлаа барьж байсан гэж бичжээ.

Энэ бүхнээс үзсэн ч Чжоу Энх-лай бол Маогийн бүлгийн дотор хамгийн нарийн аргатай хүн байсан бөгөөд Маогийн явуулж байсан балмад, бодлогыг дэмжсэн дүр үзүүлж, цаагуураа нарийн аргаар тэмцэлдэж, ялангуяа Маогийн залгамжлагч хоёрдох хүн болохоос зайлсхийдэг байсан нь түүний намтар түүхээс ч харагдаж байна. Тэрбээр Маогийн цэвэрлэ гээнд өртөлгүй албан тушаалдаа байсаар нас баржээ. Сүүлийн үед Чжоу Энх-лайн нэр хүндийг ашиглан зөвлөлтийн эсрэг үзлийг ард түмний дунд улам хүчтэй болгох талаар Бээжингийн эрх баригчид махран зүтгэгж байна.

«Дөрвийн бүлгийн» үйл ажиллагааг илчлэх явдлыг Мао, Чжоу хоёрын үхэл, түүний дараахь үйл явдалтай шууд холбож байгаа нь Мао, Чжоу нарын нэр хүндийг ашиглан хятадын олон нийтийн уур хилэн, дургүйцлийг «дөрвийн бүлгийн» зүг чиглүүлэх гэсэн зорилготой юм, «Дөрвийн бүлгийн» талынхан нам, улс, соёлын байгууллага болон аж ахуйн салбарт зонхилох байр эзэлж байсан болохоор «дөрвийн бүлгийг илчлэх энэ үе нь олон нийтийн анхаарлыг тэдний эсрэг зохион байгуулах зорилго, шинж чанартай байв.

3. Дээрх бэлтгэлийг хийсний дараа 1916 оны 11-р сарын эхээр «дөрвийн бүлгийн» үйл ажиллагааг муж, район, албан байгууллага, цэргийн ангиудад шүүмжлэн, авч хэлэлцэх ид үе эхэлжээ.

Тэдгээр шүүмжлэлээс үзвэл «Дөрвийн бүлэг» нь ХКН-ын Төв Хороо болон орон нутгийн нам, улс, цэргийн олон тооны хариуцлагатай удирдах хүмүүсийг хорлон хөнөөж зайлуулахыг эрмэлздэг байсан ажээ.

7 Жэньминь жибао, 1977. 1. 7.

8 Вэнь Чүань-шан. Чжоу Энх-лайн ирээдүй “Чжаньвань”, 1972, 8-р тал.

Тэд «Цзоузыпай» (хөрөнгөтний замаар явагчид) гэгчтэй тэмцэх нэрийдлээр Хятадын хувьсгалд оролцож байсан мянга түмэн хуучин кадрүүдыг цөм «цзоуцзыпай» болгон албан тушаалаас нь авч хаясан буюу устгасан байна.

Энэ тухай хятадын хэвлэлд бичихдээ: «Үнэн хэрэг дээр дөрвийн уршгаар хэлмэгдсэн эдгээр хүмүүс нь манай намын үй олон хувьсгалч хуучин кадр бөгөөд хятадын хувьсгалын үнэт зүйл байв»⁹ гэжээ.

«Дөрвийнхнийг» шүүмжлэх кампани нь үндэстний районуудад мөн нэгэн адил явагдах болов. Жишээ болгон дурдахад Өвөр Монголын автономит районы албан байгууллагаас нийтлүүлсэн нэгэн материалд «дөрвийн бүлэг» нь үндэстний тэгш эрх ба хэл бичгийн тэгш эрхтэй байх гэсэн намын бодлогыг дур зоригоор бусниулдаг байв. ...бүр ардчилсан хувьсгалын үед Мао дарга бидэнд анхааруулан сургахдаа: «Тэдний хэл бичиг, зан заншил, шашин шүтлэгийг хүндэтгэх хэрэгтэй» гэжээ. ... улс байгуулсанаас хойш үндсэн хуулинд олон үндэстний орон нутаг дахь автономит эрхийг бүрэн хамгаалах, үндэстнүүдийг өөрийн хэл бичгээ хэрэглэх эрхийг бүрэн хамгаалах гэдгийг тодорхойлон заажээ. «Дөрвийн бүлэг» цөөн тоот үндэстний хэл бичиг бол «хэрэгцээгүй», «ухралт» гэж үндэстний хэл бичгээ хэрэглэх, хөгжүүлэх эрхийг үгүйсгэжээ».¹⁰ гэж бичихдээ үндэстний асуудлын тухай Лениний сургаалаас иш татан оруулжээ. Үүнээс үзэхэд Өвөр Монголд «дөрвийн бүлгийг» шүүмжлэх далимаар Лениний үндэстний бодлогыг завхаруулан гуйвуулсан Маогийн үндэстний бодлогыг далдуур шүүмжилж байна гэж үзүүштэй. Ер нь үндэстний асуудлын талаархи Маогийн номлолд Лениний үндэстний бодлогын сургаалаас ганц ч үг байдаггүй байна. Энэ үед нийтлэгдэж байсан хятадын хэвлэлийн материалын гол чиглэл нь соёлын хувьсгалаар хэлмэгдсэн үй олон кадр хүчин, тэр үед гарсан алдаа завхрал, соёл шинжлэх ухаан, эдийн засгийн талаар учирсан хохирол зэрэг нь цөм л «дөрвийн бүлгийн» хорлон сүйтгэх ажиллагааны хор уршиг байв гэдгийг нотлохыг оролджээ. Энэ мэт шүүмжлэл өрнөхийн зэрэгцээ «Дөрвийн бүлэгтэй тэмцэх явдал бол өргөн олон хувьсгалч ард түмэн ХКН-ын удирдлагын дор Гоминданы хувьсгалын эсэргүүчүүдтэй урт хугацаанд хийж ирсэн тэмцлийн үргэлжлэл мөн бөгөөд пролетари нар хөрөнгөтөн ангитай тэмцэх тэмцлийн үргэлжлэл юм гэж нийтэд ойлгуулахыг гол зорилго болгож байжээ. Тухайн үеийн Хятадын хэвлэлийн шүүмжлэлийн ийм шинж чанар нь маоистуудаас явуулж ирсэн алдаа завхрал, хор хөнөөл, түүнээс учруулсан бүхий л хохирлыг цөм «дөрвийн бүлэгт» ноогдуулаад уг завхралыг гардан удирдаж байсан Маог цэвэр байлгах гэсэн хандлагатай байв. Чухамдаа «соёлын хувьсгал» гэгч нь Маогийн дэвэргэн гаргасан улс төрийн тэмцэл бөгөөд Маогийн бүлэг нам, төрийн эрхийг булаан авахын тулд «соёлын хувьсгал» гэгчээр далимдуулан ахмад коммунистууд, тэргүүний сэхээтнийг үй олноор хэлмэгдүүлсэн хувьсгалын эсэргүү улс төрийн үйл ажиллагаа байв. Тэд түүнийгээ 1968 онд өөрсдөө хүлээн зөвшөөрсөн юм.¹¹

«Дөрвийн бүлгийг» шүүмжлэх III үеийн ажиллагааны гол зорилго бол тэдний цадиггүй авирлаж байсан тухай янз бүрийн баримт гарган ирж

9 «Дөрвийн бүлгийн» хөхүүлэн бичүүлсэн хөрөнгөтний замаар замнагчидтай тэмцээ» гэсэн зохиолын хариу шинж чанар, Соёлын яамны шүүмжлэх групп. «Жэньминь жибао», 1976. 11. 22. 2-р нүүр.

10 «Дөрвийн бүлэг» намаас явуулсан үндэстний хэл бичгийн талаархи бодлогыг эвдэлсэн нь. (Өвөр Монголын холбогдох байгууллагын шүүмжлэх групп) — «Гуанминь жибао», 1977. 2. 1. 4-р нүүр.

11 Чэн Ли-шэн, Маогийн соёлын хувьсгалын» жижиг группын өөрчлөлт—«Гайкожихо» сэтгүүл. Токио. 1969. 54-р тал.

олон түмний жигшлийг төрүүлж, мөн тэдний төв ба орон нутаг дахь хамсаатныг илрүүлэхэд чиглэгдэж байжээ.

ХКН-ын X их хурлаас сонгогдсон ТХ-ны бүрэлдэхүүнээс ч үзсэн тус их хурлын дараа «дөрвийн бүлгийн» байр суурь нилээд бэхжих төлөвтэй болж, нэр нөлөө нь мэдэгдэхүйц их болжээ. Судалгаанаас үзвэл тус их хурлаар сонгогдсон Төв Хорооны жинхэнэ орлогч гишүүдийн 46,7 хувь, 29 мужийн хувьсгалт хорооны удирдах ажилтны 41,4 хувь нь тус тус Цзян Цянгийн талын буюу «дөрвийн бүлгийнхэн» байв.

Энэ тухай ХКН-ын XI их хурлын тайлан илтгэлд: «... IX их хурлаас тогтоосон улс төр, зохион байгуулалтын шугам зөв байлаа. Харин «дөрвийн бүлэг, бүх талаар X их хурлын эсрэг тэмтэж, намын зохион байгуулалтыг бусниулан манай намыг хөрөнгөтний хэв маягт оруулахыг оролдож ирэв»¹² гэж тэмдэглэснээр үзсэн ч X их хурлаар дөрвийнхний эрх мэдэл давамгайлж байсан нь харагдаж байна.

Тийм учраас ч X их хурлаас батласан ХКН-ын дүрэмд хүртэл өөрчлөлт оруулахад хүрчээ. ХКН-ын XI их хуралд намын дүрэмд өөрчлөлт оруулах тухай Е Цзян-иний тавьсан илтгэлд: «арван нэг дэх удаагийн хоёр шугамын тэмцлээр хуримтлагдсан шинэ туршлагыг харгалзан үзсэний үндсэн дээр ХКН-ын X их хурлаар батласан намын дүрэмд зохих өөрчлөлт засвар оруулах нь зүйтэй гэж тэмдэглээд «дөрвийн бүлэг» нь нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулж байсан урван тэрслэгч, тагнуул, ангийн хувьд харш үзэлтэй хөрөнгөтний шинэ элемент, зүсэн бүрийн этгээдүүдийг элсүүлж «Тэргүүний хүмүүс» гэдэг хаяг зүүгээд тэдгээр зальхай этгээдийг намын эгнээнд татан оруулж байв»¹³ гэжээ. Үүнээс үзэхэд ХКН-ын дүрэмд өөрчлөлт оруулсан явдал нь «дөрвийн бүлгийн» дэмжлэгээр намд элссэн хүмүүсийг цэвэрлэж зайлуулахад бас зарим талаар чиглэгджээ.

1977 оны 8-р сард хуралдсан ХКН-ын XI их хурлаар сонгогдсон Намын Төв Хорооны бүрэлдэхүүний 70% нь Дэн Сяо-пиний талын хүмүүс бөгөөд 29 мужийн захиргаа болон намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргын гуравны хоёр хувь. Цэргийн найман том тойргийн тавынх нь командлагч, улс төрийн комиссаар нь цөм Дэн Сяо-пиний талынхан бөгөөд Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн хурлаар томилогдсон ерөнхий сайдын орлогч 13 хүнээс зөвхөн гурван хүн нь Хуагийн талын хүн бөгөөд ард Хуа Го-фэн нь ерөнхий сайдын тушаалдаа үлдсэн хэдий боловч үнэн хэрэг дээр Дэн Сяо-пин ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байгаа юм гэж гадаадын судлаачид үзэж байна.¹⁴

Хэдий тийм боловч Маог залгамжлагч Хуа Го-фэн нь Маогийн чиг шугамыг баримтлан түүний цар хүрээнд эргэлдэн, эдийн засгийн хөгжил ихээхэн хязгаарлагдаж байгааг ойлгосон Дэн-Сяо-Пин нь эдийн засгийн кризисээс оногдох хариуцлагаасаа зайлсхийн дараачийн ээлжийн хүний гарч ирэхийг хүлээж байгаа бололтой¹⁵ гэж Японы зарим хэвлэлд бичжээ.

4. «Дөрвийн бүлгийг» шүүмжлэх кампани нь дөрвөн хүн нэг бүрт ял оногдуулан шүүмжлэх болов. Энэ нь Цзян Цин нарын дөрвөн хүний хувийн амьдрал, зан авир, цадиггүй үйл ажиллагааг янз бүрийн баримтаар шүүмжлэх хурц үе юм. Энд дөрвөн хүн тус бүрт оногдуулсан ялнаас жишээ болгон өгүүлэхэд «Цзян Цин хувьдаа улсын мөнгө хөрөнгийг туй-

12 ХКН-ын XI их хуралд Е Цзян-иний тавьсан илтгэл. (1977. 8. 13).

13 ХКН-ын XI их хуралд Е Цзян-иний тавьсан илтгэл, 1977. 8. 13.

14 «Тюокорен» 1978. № 5. 53-р тал

15 «Тюокорен» 1978. № 5, 53-р тал.

16 «Жэньминь жибао», 1977. 1.30

лын ихээр бүрэлгэн сүйтгэдэг, тэрбээр цэргийн дугаар ангид ажил шалгах нэрийдлээр очсон атлаа «тавтай нойрсож чадахгүй» гээд дур зоргоор цэргийн сургуулийн буудлагыг хориглон зогсоодог байв. «...Цзян Цин нам ба улсын их хэмжээний нууцыг дайсанд худалддаг байсан, зах дээр улс төрийн хонжоо хайж, өөрийгөө товойлгон түүнээс улс төрийн ашиг хонжоо олдог байв. Цзян Цин бол хүний цусыг сорогч улс төрийн зальт этгээд бөгөөд улсаа худалдагч мөн»¹⁷ гэж «Жэньминь жибао» сонинд бичжээ.

«Дөрвийн бүлгийн» толгойлогч Чжан Чунь-чяогийн талаар гэвэл 1976 оны 1-р сард Чжоу Энх-лай нас нөгцөж, улс даяар гашуудаж байсан үед Шанхайд «Чжан Чунь-чяог ерөнхий сайд болгоё» гэсэн «дазы бао» гарч байв. Чжан Чунь-чяо «соёлын хувьсгалыг» үзэхдээ «төрийг өөрчлөх, үеийг солих хэрэг» гэж нэрлэж байжээ. Түүнчлэн нөгөө этгээд Ван Хун-вэнь Төрийн зөвлөл, ТХ-ны цэргийн зөвлөлийн хурлын протокол, баримт бичгийг дур мэдэн Циньхуа их сургууль дахь тэдний бүлгийнхний нууц байранд аваачиж намын эсрэг үйл ажиллагаандаа ашигладаг байв»¹⁸. Тэдэнд нууц төлөвлөгөө, төв штаб, командлагч байсны дээр хүн тус бүр албан тушаалаа хувиарлан авсан байв. Тэрчлэн Ван Хун вэнь 1975 онд Шанхайд 3 сар гаруй байх хугацаандаа өдөржин идэж ууж, цэнхэж зугаалахдаа улсын хөрөнгө мөнгийг шороо мэт цацан сүйтгэв. Түүний 3 сард зарцуулсан улсын хөрөнгө нь жирийн нэг ажилчны 30 гаруй жилийн цалинтай тэнцэх юм гэх мэт зүйлийг хятадын хэвлэл нийтэлж байв.

Яо Вэнь-юаны талаар гэвэл тэр гэр бүл тавуулхнаа атал хэд хэдэн мянган хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууцыг эзэмшиж байсныг шүүмжилжээ. Түүнчлэн Яо Вэнь-шан өөрийн нэгэн өгүүлэлд: «хөрөнгөтөн анги эдийн засгийн хүчээ зохих хэмжээнд хүртэл хөгжүүлсэн цагт түүний төлөөний хүн нь улс төрийн талаар түрэмгийлэн захирахыг хүсч пролетарийн диктатур ба социалист нийгмийн өмчийг бүхэлд нь өөрчилж капиталист системийг дахин сэргээн хөгжүүлэхийг хүсдэг болно»¹⁸ гэж бичсэнийг хятадын сонин шүүмжилжээ. Үүнээс үзэхэд «дөрвийн бүлэг» болон түүний эсрэг талынхны хоорондох зөрчил тэмцэл өдөр ирэх бүр даамжирч газар авсаар байсан нь илэрхий бөгөөд харин Хятад оронд Маогийнхны балмад үйл ажиллагаанаас болж үүссэн улс төрийн дампуурал, эдийн засгийн доройтол, ард түмний ядуу зүдүү аж байдал энэ бүхний хариуцлагыг хүлээх эзэнтэй болгохгүйгээр Хуа Го-фэн өөрийн байр суурийг бэхжүүлж чадахгүй байсан нь мэдээж юм. Тийнхүү бүх бурууг «дөрвийн бүлэгт» хүлээлгэжээ.

Эцсийн бүлэгт «дөрвийн бүлгийг» Чан Кай-шитэй жишин шүүмжлэв. «Гуанминь жибао» сонины 1977 оны 7-р сарын 3-ны дугаарт «дөрвийн бүлэг» ба «Чан Кай-ши» гэдэг гарчигтай том өгүүлэл нийтлэгдсэн байв. Уг өгүүлэлд бичихдээ «Чан Кай-ши 1927 онд хятадын хувьсгалаас урваж коммунистуудыг харгислан яргалсан бол «дөрвийн бүлгийн» толгойлогч Чжан Чунь-чяо төрийн эргэлт хийж фашист «төр засаг» тогтоож, мөн намын нэрийг заавал коммунист нам гэхгүйгээр өөр нэртэй болгохыг эрмэлздэг байв. Түүний «өөр нэр» гэдэг нь Гоминьдан намын төлөөний үг байжээ. Иймээс дөрвийнхний баримталдаг хэт барууны шугам нь Чан Кай-шигийн коммунизмын эсрэг, ард түмний хувьсгалын эсрэг харгис

17 «Жэньминь жибао». 1977. 1. 30.

18 Яо Вэнь-юаны Дэми хэлэхийг няцаах нь «Чөлөөлөх армийн дугаар ангийн Ван Син-шэн. Жэньминь жибао», 1977. 3. 1.

шугамын үргэлжлэл мөн бөгөөд тэд Чан Кай-шигийн фашист үзэл санааны уламжлалыг өвлөн авч Чан Кай-шигийн нэгэн адил өөрсдийгөө «эрх мэдлийн хувилгаан» мэт үздэг байв гэжээ.

Мөн өгүүлэлд бичсэнээр бол Хятадад Линь Бяо, «дөрвийн бүлэг» хэрэв засгийн эрхэнд гарч ирсэн бол пролетарийн диктатур нь маш түргэн хугацаанд фашист диктатур болон хувирч, Чан Кай-шигийн харгис дэглэм дахин сэргэх байжээ. Энэ өгүүлэл нийтлэгдсэнээс хойш гуравхан хоногийн дараа ХКН-ын Төв Хорооны 3-р бүгд хурал (1977 оны 7-р сарын 16-- 21) хуралдаж уг бүгд хурлын тогтоолд «дөрвийн бүлгийн» тухай тусгай асуудал хэлэлцэж тэдэнд шийтгэл ноогдуулахдаа «Чжан Чунь-чяо бол Гомиьнданы тагнуул, Цзянь Цин бол урвагч, Яо Вэнь-юань бол ангийн харш этгээд, Ван Хун-Вэнь бол шинэ төрж байгаа хөрөнгөтний элемент» гэж зэмлэжээ. Улмаар ХКН-ын XI их хуралд Хуа Го-фэний тавьсан улс төрийн тайлан илтгэлийн зонхилох хэсгийг «дөрвийн бүлгийн» тухай асуудал эзэлсэн гэж хэлж болох юм. Уг илтгэлийн дотор намаас тавьж буй зорилтын 1-рт: «Дөрвөн этгээдийг» илчлэн шүүмжлэх тэмцлийг туйлд нь хүргэхийг уриалаад, «дөрвийн бүлгийн» улс төр, зохион байгуулалтын шугамын хор хөнөөл, ялзруулагч нөлөөг бүх салбарт бүрэн илрүүлэх, тэдний үйл ажиллагаатай холбоотой хүмүүсийг илчлэх, уг хэргийг бүрэн тодруулах ажлыг хойш тавилгүйгээр энэ жилд буюу түүнээс хойш асар удахгүй хугацаанд дуусгах¹⁹, цаашид «Дөрвийнхнийг» шүүмжлэх ажлыг хүчтэй үргэлжлүүлэх тухай заажээ. Тийнхүү хятадад дөрвийн бүлгийг шүүмжлэх, түүний хор уршгийг арилган цэвэрлэх ажил улс даяархи асуудах болж, улам хурц бөгөөд ширүүн шатандаа ороод байна. Сүүлийн үед дөрвийнхнийг шүүмжлэх кампани нь яамдын системийг бүхэлд нь хамарсан онолын дугуйлан, Синьхуа хорооны сурвалжлагчийн өгүүлэл зэрэг хэлбэрт шилжиж одоо гол нь түүний хор уршгийг арилгах зорилготой зохиогдож байна. Иймээс 29 мужаас 14 мужийн намын хороодын нэгдүгээр нарийн бичгийн дарга нар солигдож, мужийн хэмжээний 50 орчим удирдах ажилтан албан тушаалаасаа зайлуулагдаад байна.

Нийгмийг аюулаас хамгаалах яамны онолын дугуйлангаас «Мао даргын нийгмийг аюулаас хамгаалах ажлын бодлогыг ангийн дайсны эсрэг чиглүүлье» гэдэг өгүүлэл нийтлүүлжээ. Үүгээр ч үл барам Хуа Го-фэний тайлан илтгэлд нийгмийг аюулаас хамгаалах ажлыг хүчтэй болгож, «дөрвийн бүлгийн үл бүтэх үг ярианы хөнөөлт нөлөөнд автагдсан харгис үзэлтэн, улс үндсээс урван тэрслэгч бүх этгээдийн эсрэг илдээ хандуулахыг²⁰ уриалсан байна.

Хятадад «дөрвийн бүлгийг» шүүмжлэх кампаниар маогийнхны явуулж байсан адал балмад үйл явдлыг тал бүрээс нь илчлэн уудалж байгаа нь хэрэг дээрээ Маогийн тарьсан шившигт явдлыг нийтийн өмнө илчлээд түүнийгээ төрийн эрхийн төлөө тэмцэлдээнд ялагдсан «дөрвийн бүлэг» рүү чихэж байгаа хэрэг юм. Чухам үнэнийг хэлэхэд өрсөлдөөнд дийлсэн Хуагийн бүлэг нь дөнгөж Маог залгамжлан гарч ирэнгүүт маоизмд үнэнч байна гэдгээ амлаад улмаар Маогийн заасан замаар замнана гэдгээ ч илэрхийлжээ. Үнэхээр Бээжингийн улс төрийн бодлогод ямар ч өөрчлөлт гарсангүй гэдгийг хятадын шинэ удирдагчдын явуулж ирсэн бүхий л үйл ажиллагаа нотлон харуулж байна. Чухамдаа «дөрвийн бүлэг» гэгдэгчид нь даруй маогийнхан мөн бөгөөд Хуа Го-фэн нь мөн л маоизмыг үргэлж-

19 ХКН-ын XI их хурал дээр Хуа Го-фэний тавьсан улс төрийн тайлан илтгэл. (1977. 8. 12).

20 ХКН-ын XI их хуралд Хуа Го-фэний тавьсан улс төрийн тайлан илтгэл. (1977. 8. 12).

лүүлэн явуулагч бөгөөд харин өнөөдрийн төрийн эрх мэдлийг булаан авч дийлсний хувьд «дөрвийн бүлгээ» шүүмжилж байгаа хэрэг билээ.

Хятадын одоогийн удирдагчдын баримталж байгаа чиг шугамын талаар Ю. Цэдэнбал хэлэхдээ: «Хятадын эрх баригчид империалист хамгийн харгис хүчинтэй сүлбэлдэж, ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орны эсрэг дэлхий дахины өргөн фронт байгуулахад бүх ажил явууллагаа илэрхий чиглүүлж байна»²¹ гэжээ.

5. «Дөрвийн бүлгийг» шүүмжилж, түүний хор уршгийг арилгах ажил өнөө үед хятад орон даяар улам хүчтэй үргэлжилж байна. Нэг үгээр хэлэхэд Маогийн эхэлсэн «Соёлын хувьсгалыг» ХКН-ын XI их хурлаар дуусгавар болгоод Хуа Го-фэний шинэ маягийн «соёлын хувьсгалыг» эхэлсэн гэж хэлэхэд болохоор байна. Хуа Го-фэн энэ кампанийг нарийн зохион байгуулалт, эрэмбэ дараатай явуулж байна. Дөрвийнхний хор уршгийг арилгана гэдэг нь юуны өмнө тэдний талын хүмүүсийг зайлуулах гэсэн хэрэг юм. Тэгвэл «дөрвийн бүлэгт» хамаарах хүмүүс гэвэл Хятадын бүх хүн амын 5%-ийг эзэлж байна гэсэн мэдээ бий. Үүгээр бол дор хаяад 40 сая буюу 50 сая хүний тухай асуудлыг нэг тийш нь болох учир энэхүү цэвэрлэгээ нь тийм ч хялбархан дуусах асуудал бишээ.

Хэвлэлийн мэдээнээс үзвэл Хуа, 1977 оны эхээр Хятадын залуучуудын төлөөлөгчидтэй уулзаж ярилцахдаа «Дөрвийн бүлэгтэй» тэмцэхэд тэдэнтэй холбоо сүлбээтэй хүмүүсийг учир шалтгааныг нь ололгүй алаад, байж болохгүй, Ван, Чжан, Цзян, Яо нарт өөр өөрөөр хандана. Жишээ нь Цзян Цин муу юм их хийсэн, гэвч түүнд дээд арга хэмжээ авах нь Мао даргын нэр хүндэд нөлөөлж, намын эрх ашигт нийцэхгүй гэж хэлсэн байна.

1978 оны 2-р сарын эцэс, 3-р сарын эхээр БХАТХ-ын чуулганыг шинэчлэн хуралдуулснаар дөрвийн бүлгийн талынхныг нилээд зайлуулсан бололтой. Хуучин байнгын хорооны 144 гишүүний 80 гаруй нь, ерөнхий сайдын орлогчдын тэн хагас нь дөрвийнхний талын хүмүүс юм. Чухамдаа «дөрвийн бүлэг» гэгч нь Маогийн бүлэг л гэсэн үг юм. Иймээс стратеги нь нэг, тактик нь өөр, энэ хоёр бүлгийн хоорондох зөрчил нь эцсийн эцэст засгийн эрхийн төлөө тэмцэл юм.

Удирдлаганд шинэ хүн гарч ирэхээр түрүүчийн хүний талынхныг өөрчлөх нь Хятадад дэлгэрсэн практик юм. Жишээ нь: Линь Бяогийн хэрэг явдлаас өмнө Хятадын 29 мужийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нарын 21 нь цэргийн хүн байсан бол Линь Бяогоос хойш дээрх 21 хүнээс 11 хүнийг өөрчлөхийн зэрэгцээгээр мужийн намын хорооны удирдах бүрэлдэхүүний орон тоог нэмсэн байна. Жишээ нь: 1976 оны эхээр Хунань мужийн намын хорооны удирдах бүрэлдэхүүн 3 хүн байсныг 8, Хэйлунцзян мужийнх 5 байсныг 10, Юаньнань мужийнх 4 байсныг 9 болгон тус тус нэмэгдүүлж Шанхай хот, Цзилин муж хоёроос бусад, 27 мужийн намын удирдлагад 87 шинэ хүн оруулжээ.

Одоо «дөрвийн бүлгийн» талынхныг зайлуулах ажил явагдсаар л байна. Маогийн практикаас үзвэл ял нь их тусам тэр хүн амьд үлдэж, харин ял зэмлэл бага тусам амархан хороогддог байна. Хуа Го-фэн ч ийм аргаар ажиллаж байна. Тийм учраас одоо Хятадад сэхээтнүүдийнхээ дотор дахин цэвэрлэгээ хийж байгаа тухай хятадын өөрийн нь болон гадаадын хэвлэл мэдээлсээр байна. Энд зөвхөн нэг жишээ дурдахад 1977 оны 2-р сард Шанхай, Гуанчжоу-д 30 гаруй хүнийг цаазласны дотор Шанхайн 26

21 Улаанбаатар хотын намын XIX бага хурал дээр МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын хэлсэн үг.

хүн нь «хувьсгалын эсэргүү этгээд» бөгөөд Гуан-чжоу-гийн 10 гаруй хүнийг «тагнуул» гэдэг ял заан цаазаар аваачсан байна.²² Үүний зэрэгцээгээр «дөрвийн бүлэгт» хэлмэгдсэн зарим хүмүүсийг цагаатгаж байна. Тухайлбал, 1977 оны сүүлийн хагаст ялангуяа улс төр, урлаг утга зохиолын олон зүтгэлтнийг гаргаж ирэв. Үүнд: Чжоу Ян, Се Бин-синь, Ван Чао-вэнь зэрэг нэрт сэхээтнүүдийг дурдаж болно. Тэдгээрийн дотор хятад бус үндэстний төлөөлөгчид ч орж байна.

Сэхээтний талаар Маогийн явуулж байсан бодлогын зарим зүйлийг «дөрвийн бүлэг»-тэй холбон шүүмжилж, соёлын зүтгэлтнүүдийг цагаатган, утга зохиол, урлагийн зарим бүтээлийг сэргээж ашиглах алхамд шилжиж байна.

1978 оны эхээр Өвөр Монголын зохиолч Н. Сайнцогт, Малчинхүү, жүжигчин Буяндэлгэр, Ч. Боргио, Муу-охин, Сэцэндар-эх гэх мэт хүмүүсийг цагаатгажээ. Үүгээрээ Хуа Го-фэн болон хятадын шинэ удирдлаганд хятад бус үндэстний дотор нэр сүл хожих, мөн тэдгээр хүмүүсийн эрдэм мэдлэг, дадлага туршлагыг ашиглах шаардлагатай болсныг харуулж байна.

Маогийн их гүрний дээрэнгүй жанжлах бодлогыг өвлөн залгамжлагч Хуа Го-фэн нь Лин Бяо болон «дөрвийн бүлэгтэй» тэмцэх нэрийн дор маоизмын хямралыг аль нэгэн хэмжээгээр намжаах гэсэн зальхай бодлого явуулж хэрэг дээрээ маоизмын хор уршгийг улам хүндрүүлж байна.

Ц. Бавуудай

КАМПАНИЯ ПО КРИТИКЕ «БАНДЫ ЧЕТЫРЕХ» КАК ОЧЕРЕДНОЙ КРИЗИС МАОИЗМА

Резюме

Автор статьи, анализируя данные китайской прессы, рассматривает вопрос о критике «банды четырех», развернувшейся в Китае после смерти Мао Цзэ-дуна.

Хуа Го-фэн развернул шумную политическую кампанию по критике «банды четырех» с целью свалить всю вину маоистского руководства на своих противников и тем самым сохранить авторитет Мао Цзэ-дуна и маоистского учения для укрепления своего положения в китайском руководстве.

Масштабы кампаний политических преследований сторонников «четверки» под лозунгом борьбы с последствиями подрывной деятельности «банды четырех» непрерывно расширяются. Чистка осуществляется во всех звеньях центрального и местных органов государственной власти, общественных организаций, средств массовой информации и др.

В статье автор приводит конкретный пример очистке сторонников «четверки», занимавших высокие партийные и государственные посты. Так например, 47,6% членов ЦК, избранных X съездом КПК и 41,4% руководящих работников 29 провинций были сторонниками Цзян Цин и «банды четырех». Чистка сторонников «четверки» на деле означала устранение нежелательных новому руководству лиц от занимаемых ими должностей. По данным китайской прессы 5% всего населения, то есть свыше

40 миллионов человек, были сторонниками «четверки». Это означало, что кампания по критике «четверки» затрагивала в той или иной степени судьбы многочисленных людей.

В настоящее время критика «четверки» далеко еще не закончена. Особо она усилилась среди интеллигенции. Кампания критики «четверки» не ограничивается только отстранением от должностей, но и часто сопровождается казнями и жестокими расправми. Так например, в Шанхае, Ханьчжоу и других городах в начале 1977 года были приговорены к смерти более 30 человек. Следует отметить, что методы и средства борьбы Хуа Го-фэна со своими политическими противниками мало чем отличаются от тех же средств и методов, которые получили широкое распространение в период «культурной революции»,

По мнению автора, критика «банды четырех» и чистка ее сторонников является «культурной революцией» «нового типа», начатая Хуа Го-фаном по примеру предыдущей «культурной революции» Мао Цзэдуна.

В заключение делается вывод о том, что маоистская позиция Хуа Го-фэна выражается в его прямом унаследовании и продолжении маоистской политики великодержавного гегемонизма, направленной против мирового социализма, мира и прогресса во всем мире

Наиболее реакционной доктриной, которую Хуа Го-фэн положил в основу внешнеполитического курса нынешнего китайского руководства, является «теория трех миров». По мнению автора статьи, кампания по критике «банды четырех» не внесла никаких изменений в антисоциалистический, маоистский характер политики китайского руководства.